



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд
Регистрийн дугаар №8398801

2023 оны 12 сарын 05 өдөр

№ 17

Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.1 заалт, 7.6 дахь хэсгийн 7.6.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.4, 28.1.15 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нөлөөлөгч нарын дотоод аяллын маршрутыг тодорхой болгох, төсвийг шийдвэрлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүргийг гадаад зах зээлийн чиг үүргийн хороонд шилжүүлсүгэй.
2. Гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулахад Ажлын алба дэмжиж ажиллахыг үүрэг болгосугай
3. Хойшлогдсон салбар холбооны асуудлыг Б.Золбадрал, Б.Дуламсүрэн нар хариуцах, батлагдсан салбар холбооны нэмэлт тайлбар мэдээллийг Ажлын албанаас ирүүлсүгэй.
4. Булган, Төв, Хөвсгөл аймгуудад салбар холбоо байгуулах асуудлыг хариуцсан гишүүд/В.Батзориг, О.Мөнхнасан/ 2023 оны 12-р сарын 08 өдрийн онлайн хуралд оруулсугай.
5. 2023 оны 12-р сарын 11-ний өдөр зохион байгуулагдах “Ногоон хөрөнгө оруулалт-аялал жуулчлалын чуулган”-ыг удирдах зөвлөлийн гишүүн О.Мөнхнасан, Бүх гишүүдийн хуралдааныг удирдах зөвлөлийн гишүүн Б.Золбадрал, М.Нарангэрэл, хуульч, өмгөөлөгч Д.Дашдорж нар хариуцсугай.
6. Аялал жуулчлалын шагнал, авардсыг “шилдэг бүтээн байгуулалт”, “шилдэг эвент” категориор олгож, шагнал авардс сонгон шалгаруулах асуудлыг Э.Цоморлиг, Ч.Бат-Эрдэнэ, Ч.Болорхүү, Ц.Ганзориг нар хариуцан ажиллахыг үүрэг болгосугай.
7. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны 2024 оны төлөвлөгөөг 12-р сарын 11-17 өдрүүдэд боловсруулсугай.
8. Сургалт судалгаа, цахим шилжилтийн чиг үүргийн хорооноос Цахим шилжилтийн чиг үүргийг хасч, Цахим шилжилт харилцаа хорооны чиг үүргийн холбоог шинээр байгуулсугай.

9. Цахим шилжилт харилцаа хорооны чиг үүргийн хорооны тэргүүнээр
Э.Цоморлигийг нэг жилийн хугацаатай томилсугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГИШҮҮД



Б.ЗОЛБАДРАЛ
Б.ИЖИЛМӨРӨН
Ч.БАТ-ЭРДЭНЭ
М.НАРАНГЭРЭЛ
Г.ОТГОНБААТАР
О.МӨНХНАСАН
Ч.БАТХУЯГ
Ч.БОЛОРХҮҮ
Э.ЦОМОРЛИГ
С.АЛТАНТУЯА
М.НАРАНГЭРЭЛ